

**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН**

Огноо: 2025.12.31

Төлөөлөн удирдах зөвлөл:

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Нэрс	Төлөөлөн удирдах зөвлөл	Томилогдсон огноо	Чиг үүрэг	2025 оны хурлын ирц
Б.Артур	Дарга	2024.09.13	Төрийн төлөөлөл	100%
Н.Мөнхбат	Гишүүн	2023.07.05	Төрийн төлөөлөл	100%
Х.Итгэлт	Гишүүн	2023.11.02	Төрийн төлөөлөл	100%
С.Мяндасмаа	Гишүүн	2022.09.19	Төрийн төлөөлөл	100%
Н.Ганболд	Гишүүн	2022.11.22	Төрийн төлөөлөл	100%
Б.Амарбаясгалан	Гишүүн	2022.09.29	Төрийн төлөөлөл	100%
Д.Нар-Од	Гишүүн	2025.05.22	Хараат бус	100%
Ж.Ариунаа	Гишүүн	2025.05.22	Хараат бус	100%
Д.Янжинсүрэн	Гишүүн	2025.05.29	Хараат бус	100%

2025 оны ТУЗ-ийн бүрэлдэхүүний өөрчлөлт:

- Хараат бус гишүүн Д.Нэмэхбаяр 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр чөлөөлөгдсөн.
- Хараат бус 1 гишүүний сул орон тоонд сонгон шалгаруулалтаар хараат бус гишүүн Д.Янжинсүрэн томилогдсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчийн удирдамж чиглэл болон холбогдох хууль тогтоомжийг баримтлан, компанийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг гарган, гүйцэтгэх удирдлагын багт үүрэг даалгавар, чиглэл өгч ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч:

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг 2025 оны 09 дүгээр сар хүртэл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хэрэгжүүлж ажилласан. Монгол улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 137 дугаар тогтоолоор “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр “Эрчист Монгол” ТӨХК-ийг тогтоосон бөгөөд тус хувьцаа эзэмшигчийн өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулж, 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Хараат бус гишүүд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн бүрэн эрхийн хугацаа Компанийн тухай хуулийн 77.2-т заасны дагуу дараа жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болдог бөгөөд 2025 оны 04 дүгээр сард Хувьцаа эзэмшигчээс сонгон шалгаруулалт явуулах удирдамж,

чиглэл ирсний дагуу хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, гишүүдийг томилсон. /Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”/

Хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон ТУЗ, хороодын ажиллах журамд заасан эрх үүргээ идэвхтэй хэрэгжүүлдэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд хараат бус гишүүдийн оролцоог хуулийн хүрээнд бүх талаар бүрэн хангаж ажилладаг. 2025 онд ТУЗ-ийн 24, хороодын 26, нийт 50 удаагийн хуралд хараат бус гишүүд 100 хувийн ирцтэй оролцсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороод:

Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3, хороодын 2/3 нь хараат бус гишүүн байх заалтын хүрээнд хороодын бүрэлдэхүүнийг баталсан. Хороодын хурлаас гишүүдийн саналыг нэгтгэн холбогдох санал зөвлөмж, дүгнэлтийг гарган компанид хүргэж, хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажилладаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор хороодыг шинэчлэн байгуулсан бөгөөд Компанийн тухай хуулийн 82.1-д “... хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж заасны дагуу байгуулсан болно.

	Хороод	Нэрс
Аудитын хороо	1.Хорооны дарга	Д.Нар-Од /хараат бус/
	2.Гишүүн	Ж.Ариунаа /хараат бус/
	3.Гишүүн	Х.Итгэлт
	4.Гишүүн	Б.Амарбаясгалан
	5.Гишүүн	Д.Янжинсүрэн /хараат бус/
Нэр дэвшүүлэх хороо	1.Хорооны дарга	Н.Мөнхбат
	2.Гишүүн	Д.Нар-Од /хараат бус/
	3.Гишүүн	Ж.Ариунаа /хараат бус/
Цалин, урамшууллын хороо	1.Хорооны дарга	Н.Ганболд
	2.Гишүүн	С.Мяндасмаа
	3.Гишүүн	Ж.Ариунаа /хараат бус/
	4.Гишүүн	Д.Нар-Од /хараат бус/
	5.Гишүүн	Д.Янжинсүрэн /хараат бус/

Компанийн хяналтын тогтолцоонд Аудитын хороо нь чухал үүрэгтэй. Аудитын хороо нь Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд компанийн санхүү болон үйл ажиллагааг хянан шалгахдаа дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлж, компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, хяналт дотоод аудитын нэгжүүд, холбогдох албан тушаалтнуудад шаардлагатай заавар зөвлөмжийг тухай бүр өгч, хяналт тавьж үр дүнтэй хамтран ажилласан. Аудитын хорооны дарга, хараат бус гишүүн Д.Нар-Од “Эдийн засгийн зорилтот түвшин, төсөв төлөвлөгөө болосвруулахад анхаарах асуудал” сэдвээр компанийн удирдах түвшний ажилтнуудад сургалт явуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Компанийн тухай хуульд заасан Нарийн бичгийн даргын /82 дугаар зүйл/ үндсэн чиг үүргийн хүрээнд Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам, Хороодын журам, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалын тодорхойлолт зэрэгт тодорхой заасан эрх үүргийг хэрэгжүүлж, холбогдох бусад

хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд, Төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, хурал зохион байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулах ажлуудыг гүйцэтгэж, Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангаж ажилласан. 2025 онд нийт 54 хурал, 1 дотоод томилолтыг зохион байгуулж, 88 шийдвэрийг албажуулж, ирсэн 41, явсан 56, нийт 97 албан бичгийг хөтөлсөн. 2024 оны нийт бичиг хэргийг архивлаж, нийт 22 боть материал архивт өгсөн.

2025 оны хурлын мэдээлэл:

Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 онд 24 удаа хуралдаж, 38 тогтоол, 12 тэмдэглэл баталж гаргасан байна.

Аудитын хороо 20 удаа хуралдаж 28 дүгнэлт, санал зөвлөмж баталж гаргасан байна. Нэр дэвшүүлэх хороо 3 удаа, Цалин, урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдаж холбогдох дүгнэлтийг гаргасан байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан Нэр дэвшүүлэх түр хороо 4 удаа хуралдаж, 2 дүгнэлт гаргасан. Нэр дэвшүүлэх түр хороо нь хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн удирдамж, Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын хүрээнд хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд холбогдох шийдвэрийг гарган Хувьцаа эзэмшигчид хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Боловсруулсан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Б.Гэрэлзул